



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар

A/222

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ЖАЙКА” ОУ-ын байгууллагатай хамтран зохион байгуулах “Хүүхдийн амьлуулах суурь тусламж үзүүлэгч болон зааварлагч” бэлтгэх сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
08. өдрийн 4 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
6222



ХҮҮХДИЙН АМЬЛУУЛАХ СУУРЬ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОН
ЗААВАРЛАГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эрүүл мэндийн салбарын нөхцөл байдал сайжирсаар байгаа хэдий ч хот, хөдөөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээ харилцан адилгүй, өвчлөлийн бүтэц өөрчлөгдөж халдварт бус өвчин, осол гэмтэл нэмэгдэх болсон. Мөн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо нь боловсронгуй болоогүй гэх мэт асуудлууд тулгарч байна.

ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага нь анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлж байна. Үүнд яаралтай тусламж зэрэг нэн түрүүнд сайжруулах шаардлагатай чиглэлүүдэд илүү анхаарал тавьж ажиллаж байна.

Хүүхдийн яаралтай тусламжийн чиглэлээр явуулах сургалтын сэдвийн талаар ЭМЯ, ЭМХТ, ЭХЭМҮТ-н холбогдох ажилтнуудтай санал солилцсоны үр дүнд, урьд өмнө нь хүүхдийн амилуулах тусламжийн арга техник багтсан системтэй сургалт зохион байгуулагдаж байгаагүй учраас хүүхдийн амилуулах суурь тусламжийн сургалтыг (Pediatric Basic Life Support) явуулж мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх талыг илүү баримтлах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Хүүхдийн амилуулах суурь тусламжийн сургалт нь тусгай багаж хэрэгсэл шаардагдахгүй, зүрх уушигны сэхээн амьдруулах (ЗУСА) үйл ажиллагааны тухай заадаг сургалт бөгөөд энэ нь дэлхийн аль ч улсад адилхан агуулгатай байдаг. Сургалтын материал болон гардан үйлдэл хийх агуулгын хувьд Азийн улс орнуудад явагддаг сургалтаас санаа авч, Монгол Улсын нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулсан. Монгол Улсад хүүхдийн амилуулах суурь тусламж болон яаралтай тусламж үйлчилгээ үзүүлж буй бүх эмнэлгийн мэргэжилтэнд зориулан энэхүү сургалтыг зохион байгуулснаар зүрх уушигны зогсолтын байдалд орсон хүүхдэд тусламж үзүүлэх ур чадвар сайжирч, улсын хэмжээнд анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээний түвшин дээшилнэ гэж харж байна. Сургалтыг хоёр, гурав дахь шатлалын эмч нарын оролцоотойгоор зохион байгуулснаар тэдний сурган заах чадварыг мөн давхар сайжруулах боломжтой юм.

Зорилго:

Зүрх уушигны зогсолтын байдалд орсон хүүхдэд ямар нэгэн тусгай багаж хэрэгсэл ашиглалгүйгээр анхан шатны тусламж үзүүлэх арга эзэмших

Зорилт:

- 1) Хүүхдийн амилуулах суурь тусламжийг үр дүнтэй үзүүлэхэд шаардлагатай мэдлэг эзэмших
- 2) Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэх үндсэн ур чадвар эзэмших
- 3) Хүүхдийн амилуулах суурь тусламжийн сургалтын заах арга эзэмших

Сургалтын хэлбэр:

Богино хугацааны сургалт (Хүүхдийн амилуулах суурь тусламжийн сургалтын хэсэг – 4 цаг, зааварлагчийн сургалтын хэсэг – 4 цаг)

Хамрагдагсад:

Хүүхдийн эмч нар

Сургалт болох газар:

ЭМХТ-ийн хурлын танхим

Эзэмших мэдлэг:

Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэх тухай мэдлэг, хүнд шинж тэмдэгтэй хүүхдийн онцлог

Эзэмших чадвар:

Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэх ур чадвар, түүний сурган заах арга зүй

Эзэмших хандлага:

Яаралтай үед хүүхдэд тохирсон эмнэлгийн тусламж үзүүлэх чин сэтгэлтэй, Монгол Улсын хүүхдийн яаралтай тусламжийг сайжруулахад хувь нэмрээ оруулах хандлага

Сургалтын хэрэглэгдэхүүн:

Нялх хүүхдийн манекин 2, хүүхдийн манекин 2, хүүхдийн амбу маск 2 иж бүрдэл, сургалтын автомат тохируулгат дефибриллятор, сургалтын ширээ 2ш, проектор, компьютер, дэлгэц

Сургалтын арга зүй:

Лекц, дадлага, багийн ажиллагаа

Багшлах боловсон хүчин:

- Хүүхдийн яаралтай тусламжийн сургалт хариуцсан сургагч багш

Зөвлөх багш нар:

№	Овог нэр	Албан байгууллага	Мэргэжил, боловсролын зэрэг	Ажилласан жил
1	Иноүэ Нобуаки	Японы олон улсын эрүүл мэндийн судалгааны төв, сургалтын алба	Хүүхдийн яаралтай тусламж, M.D, MPH	23
2	С.Алтансүх	УНТЭ яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр	20
3	О.Янжив	УГТЭ Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр	22
4	Б.Батсайхан	ГССҮТ Яаралтай тусламжийн тасгийн эмч	АУ-ны магистр	15
5	Ө.Анхболд	СЭМҮТ Яаралтай тусламжийн тасгийн эмч	АУ-ны магистр	20
6	Ц.Чинбаяр	ХӨСҮТ Яаралтай тусламжийн тасгийн эмч	АУ-ны магистр	21


Ашигласан материалын эх сурвалж:

- Хүүхдийн амилуулах суурь тусламжийн сургалтын материал
- Зааварлагчийн гарын авлага

Сургалтын хөтөлбөр:

Цаг	Сургалтын агуулга	Төрөл	Минут
08:30 - 08:35	Танилцуулга (нээлтийн үг)		5
08:35 - 08:55	Сургалтын өмнөх тест (олон сонголт бүхий 20 асуулт)	тест	20
08:55 - 09:15	Ерөнхий ойлголт (үзүүлэх сургалтын видео үзэх)	лекц	20
	- Шинэчлэгдсэн удирдамж/алгоритм		
	- Нялх хүүхэд болон хүүхдийн хариу үйлдэл, амьсгал, цусны эргэлтийг хэрхэн үнэлэх вэ?		
	- ЗУСА-ыг үр дүнтэй хийх гол зарчмууд		
	- Нялх хүүхэд болон хүүхдэд хиймэл амьсгалыг хэрхэн үр дүнтэй хийх вэ?		
09:15 - 09:30	Цээж шахалт (нялхас & хүүхэд)	дадлага	15
	- 2 хурууны арга		
	- 2 эрхий хуруу-гарыг цээж тойруулан барьж хийх арга		
	- Нэг гарын цээж шахалт		
09:30 - 09:45	Хиймэл амьсгал	дадлага	15
	- Амаар аманд		
	- Амаар ам-хамарт		
	- Амбу маскаар амьсгал өгөх (1 хүн/2 хүн)		
09:45 - 09:55	завсарлага		10
09:55 - 10:00	Нялх хүүхдийн ЗУСА (1 & 2 аврагч)	лекц	5
10:00 - 10:20	- Үзүүлэх сургалтын видео үзэх	дадлага	20
	- Нялх хүүхдийн ЗУСА 1 болон 2 аврагчтай хийх дадлага		
10:20 - 10:25	Хүүхдийн ЗУСА (1 & 2 аврагч)	лекц	5
10:25 - 10:45	- Үзүүлэх сургалтын видео үзэх	дадлага	20
	- 1 болон 2 аврагчтай хүүхдийн ЗУСА хийх дадлага		
10:45 - 10:50	Автомат тохируулгат дефибриллятор (AED)	лекц	5
10:50 - 11:05	- Үзүүлэх сургалтын видео үзэх	дадлага	15
	- AED хэрэглэх дадлага хийх		
11:05 - 11:15	завсарлага		10
11:15 - 11:35	Сценари (ур чадвар шалгах)	тест	20
	- Нялх хүүхдийн ЗУСА 1 хүн болон 2 хүн хийх сценари: тус бүр нэг сценари		
11:35 - 11:40	Гадны биетээр амьсгалын зам бөглөрөх (нялхас & хүүхэд)	лекц	5
11:40 - 11:55	- Нялх хүүхэд болон хүүхдийн амьсгалын зам бөглөрсөн үед авах арга хэмжээ	дадлага	15
	- Үзүүлэх сургалтын видео үзэх		
	- Нуруу доргиох - цээж шахах, хэвлийн шахалт хийх дадлага		
11:55 - 12:15	Сургалтын дараах тест (85%-с дээш оноо авбал тэнцэнэ)	тест	20
12:15 - 12:20	Дүгнэлт (сургалтыг дүгнэх, асуулт & хариулт)		5
12:20 - 12:30	Хаалт (гэрчилгээ гардуулах, хаалтын үг)		10
	Нийт		240

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын 08 өдрийн А/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
1222



**“ХҮҮХДИЙН АМЬЛУУЛАХ СУУРЬ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОН
ЗААВАРЛАГЧ БЭЛТГЭХ”
СУРГАЛТАД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ**

3 өдрийн сургалт

№	Хэрэглэгдэх зүйлс	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бичиг хэргийн зардал	1 хүн	69	2.000	138.000
2	Гэрчилгээ	1 хүн	69	1.000	69.000
3	Цайны зардал	1 хүн/өдөр	69*6	2.000	828.000
4	Хоолны зардал	1 хүн/өдөр	69*3	6.000	1242.000
6	Багшийн цагийн хөлс /магистр/	хүн *цаг	12*8	10.000	960.000
Нийт зардал					3.237.000

Хянасан:

Д.Гантуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Боловсруулсан:

О.Баярсайхан

О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/